

**ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 3 ДУГААР САРЫН 1 ДЭХ
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА**

№ 8

2018.03.01

Өлгий сум

Нэг: Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал.

Тус Цагдаагийн газар энэ 7 хоногийн хугацаанд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 52 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд 9 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн.

Мөн 1 гомдол, мэдээлэлд хэрэг нээхээс татгалзсан.

Хулгайлах хэрэг 1, хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг 2, бусад төрлийн 6 хэрэг тус тус бүртгэгдсэн.

Нийт 156 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 136 хүнд 4.490.000 төгрөгийн тогуулийн шийтгэл оногдуулсан, 3 хүн баривчлагдсан, 20 хүн эрүүлжүүлэгдсэн.

**Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх болон бусад чиглэлээр
хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ.**

1. Тус аймгийн Ногооннуур сумын 8 дугаар багийн иргэн А-ийн адуу хулгайд алдагдсан гэх гомдол мэдээллийн дагуу Ногооннуур сум дахь Цагдаагийн тасгийн алба хаагчид Хилийн цэргийн дугаар ангийн алба хаагчдын хамтаар эрэн сурвалжлах явцад тус сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэр болох "Асгат" гэх газар ОХУ-ын БН Тува улсын 4 иргэд хууль бусаар Монгол улсын хил нэвтэрч, бүлэглэн адуу хулгайлсан болохыг тогтоон, гэмт этгээдүүдийг саатуулсан.

Иймд хил орчимын бүс нутагт оршин сууж байгаа малчин, ард иргэдэд хил дамнансан мал хулгайлах гэмт хэрэгт өртөхөөс сэргийлж, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахыг Уриалж байна.

2. Цагдаагийн газраас Өлгий сумын тавдугаар багийг хяналтын камерын бүс болгох ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.

Тус баг нь 689 өрх, 2992 хүн амтай аймгийн төвийн томоохон багуудын нэг юм. Багийн нийт нутаг дэвсгэрийн дийлэнх хэсэг нь хотын "А" бүсэд хамаардаг ба төрийн болон төрийн бус байгууллага, худалдаа, үйлчилгээний газар, төвлөрсөн захууд үйл ажиллагаа явуулдаг. Өнгөрсөн онд аймгийн төвд үйлдэгдсэн нийт 41 хулгайлах гэмт хэргийн 44 хувь нь тавдугаар багт үйлдэгджээ. Одоогоор багийн нутаг дэвсгэр дэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн 82 хувь нь хяналтын камер суурилуулжээ. Цагдаагийн байгууллагын зүгээс хяналтын камер суурилуулаагүй байгууллагуудад албан шаардлага хүргүүлж байгаа аж. Одоо нэмж 25 байгууллага камертай болсон тохиолдолд тус багийг бүхэлдээ хяналтын камерын бүс болгох боломж бүрдэж, гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурна.